



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй гурван удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй 5 нэрийн нийт 6,745,462,577.64 (зургаан тэрбум долоон зуун дөчин таван сая дөрвөн зуун жаран хоёр мянга таван зуун далан долоон төгрөг жаран дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 5,104,192,534.00 (таван тэрбум нэг зуун дөрвөн сая нэг зуун ерэн хоёр мянга таван зуун гучин дөрвөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Худалдан борлуулснаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
133031371

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны ...*А*... дугаар сарын *24* өдрийн
294... дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Тоо хэмжээ /ш/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэлбэгээр худалдаснаас олох орлогын доод хэмжээ
1	2	3	4	5	6	7
1	Экскаватор ,ЭКГ-15 ех № 19	1	5,632,344,406.00	4,969,109,528.00	663,234,878.00	330,000,000.00
2	Экскаватор Р 954 /50-01749/	1	1,038,603,850.28	70,193,450.00	968,410,400.28	3,000,000.00
3	Масло түгээгүүр 367М5ДЭ С235Д.02.000	1	24,838,107.12	21,629,852.00	3,208,255.12	-
4	Масло түгээгүүр 367М5ДЭ С235Д.02.000	1	24,838,107.12	21,629,852.00	3,208,255.12	-
5	Масло түгээгүүр 367М5ДЭ С235Д.02.000	1	24,838,107.12	21,629,852.00	3,208,255.12	-
		5	6,745,462,577.64	5,104,192,534.00	1,641,270,043.64	333,000,000.00
	НИЙТ ДҮН		(зургаан тэрбум долоон зуун дөчин таван сая дөрвөн зуун жаран хоёр мянга таван зуун далан долоон төгрөг жаран дөрвөн мөнгө)	(таван тэрбум нэг зуун дөрвөн сая нэг зуун ерэн хоёр мянга таван зуун гучин дөрөв)	(нэг тэрбум зургаан зуун дөчин нэгэн сая хоёр зуун далан мянга дөчин гурван төгрөг жаран дөрвөн мөнгө)	(гурван зуун гучин гурван сая)